



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/569

Хэрлэн сум

Хөрөнгө оруулалтын чуулган зохион
байгуулахад хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 20 дугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуй нэгж байгууллагыг дэмжиж, хамтран ажиллах, Хэнтий аймагт төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, бизнес эрхлэх боломжуудыг танилцуулж, гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг татаж, аймаг болон бүс нутгийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулж буй “Invest Khentii 2023” хөрөнгө оруулалтын чуулган зохион байгуулахад 5,700,000 (таван сая долоон зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын “Нээлттэй аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны.....дугаар сарын 10-ны
.....дугаар захирамжийн хавсралт

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧУУЛГАНЫ
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ	Нэгж үнэ ₮	Нийт дүн ₮
1	Цайны завсарлага	ш*2 удаа	1200	4500	5 400 000
2	Цэвэр ус	ш	100	1 500	150 000
3	Чуулгын танхимын түрээс	өдөр	1	150 000	150 000
	Нийт дүн				5 700 000